



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

「 Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015-2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 4,452,534,891.00 (дөрвөн тэрбум дөрвөн зуун тавин хоёр сая таван зуун гучин дөрвөн мянга найман зуун ерэн нэгэн) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга Ч.Сайханбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, эзэмшигчийг тогтоож (Налайх дүүргийн “Баянгол хүүхдийн зуслан” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар) бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

139005480
14-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн
237 дугаар тогтоолын хавсралт

Нийслэлийн (Налайх дүүргийн “Баянгол хүүхдийн зуслан” орон нутгийн өмчит
үйлдвэрийн газар эзэмших) өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /тегергөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Баянгол хүүхдийн зуслангийн цогцолбор барилга байгууламж /Улаанбаатар хот Налайх дүүрэг, 6-р хороо/	1-2 давхар, 17 блок, театр, 6 машины гараж, гадна тохижилт, 209 хүүхдийн хүчин чадалтай, зорьгүй	4,452,534,891.00	2021-1109 УҚД- БА-230/2021, 2022-12-26 УҚД-БА-293/2022
	Нийт дүн		4,452,534,891.00 (дөрвөн тэрбум дөрвөн зуун тавин хоёр сая таван зуун гучин дөрвөн мянга найман зуун ерэн нэгэн)	